

Алсын дуудлагын үйл ажиллагааг зохицуулах журам 2023 он



**АЛСЫН ДУУДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

Хувилбарын дугаар: 01

Хүчин төгөлдөр болсон огноо: 2023-07-05

Баримт бичгийн дугаар

| Баримт бичгийг хариуцах нэгж       | Яаралтай тусламжийн тасаг |  |  |
|------------------------------------|---------------------------|--|--|
| Баримт бичгийн нууцлалын зэрэглэл: | Дотоод                    | Баримт бичгийн түвшин  | 2  |
|                                    |                           | Албан тушаал   | Гарын үсэг   |
| Боловсруулсан:                     |                           | ЭЭДЗахирал<br>Д.Болормаа<br>Яаралтай тусламжийн эрхлэгч<br>Э.Мөнхцэцэг<br>Сувилахуйн арга зүйч<br>Н.Нямсүрэн | <i>[Handwritten signature]</i><br><i>[Handwritten signature]</i> |
| Санал өгсөн:                       |                           | ЭТҮЧАДарга<br>Ц.Лувсандамдин   | <i>[Handwritten signature]</i>                                   |
| Хянаж батласан:                    |                           | Захирал:<br>Г.Дашжанцан  | <i>[Handwritten signature]</i>                                   |



**Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл**

| <b>Хувилбарын дугаар</b> | <b>Хүчин төгөлдөр болсон огноо</b> | <b>Өөрчлөлтийг батласан албан тушаалтан</b> | <b>Өөрчлөлтийн утга</b><br>(баримт бичигт ямар өөрчлөлт орсонг товч тайлбарлана) |
|--------------------------|------------------------------------|---|--|
| 1                        |                                    |   | Баримт бичгийн анхны хувилбар  |
| 2                        |                                    |   |  |
| 3                        |                                    |   |  |

**АГУУЛГА:**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ /3/
2. ХАМРАХ ХҮРЭЭ/3/
3. НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГ, ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД /3/
- 3.1 Нэр томьёо/3/
- 3.2 Товчилсон үг/3/
- 3.3 Иш татсан баримт бичгүүд/3/
4. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА МАТРИЦ /4 /
5. АЛСЫН ДУУДЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЗАРЧИМ /5/
6. АЛСЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАХ /6/
7. АЛСЫН ДУУДЛАГЫГ ШИЙДВЭРЛЭХ /6/
8. АЛСЫН ДУУДЛАГАНД АЖИЛЛАХ МЭРГЭЖЛИЙН БАГИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА /6/
- 8.1 Багийн ахлагчийн үүрэг, хариуцлага /6/
- 8.2 Эмчийн үүрэг, хариуцлага /7/
- 8.3 Сувилагчийн үүрэг, хариуцлага /7/
- 8.4 Алсын дуудлагын жолоочийн үүрэг, хариуцлага /7-8/
9. АЛСЫН ДУУДЛАГА ДУУДАХ ЭМНЭЛГИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА /8/
10. АЛСЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГЫГ ДҮГНЭЖ ТАЙЛАГНАХ /8/
11. ХАРИУЦЛАГА /8/
12. ЭМ ЭМНЭЛЭГИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ /8-15/
- 12.1 Дотрын чиглэлийн алсын дуудлагын цүнхний эм хэрэгслийн жагсаалт /9-11/
- 12.2 Эх барихын алсын дуудлагын цомог, эм тариа нэг удаагийн хэрэгслийн /11-жагсаалт /9-13/
- 12.3 Гэмтэл мэс заслын биксний эм тариа нэг удаагийн хэрэгслийн жагсаалт /13-15/ Шалгуур үзүүлэлт /15/

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмын зорилго нь харьяа аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын нэгдсэн эмнэлэг, СЭМТөвөөс ирүүлсэн дуудлагын дагуу БОЭТөвөөс төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлээр яаралтай тусламжийн үйлчилгээг үзүүлэх, Төв эмнэлэгүүдэд өвчтөн тээвэрлэн хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино

1.2 Алсын дуудлага дуудах, лавалгаа шатлалын эмнэлэгт өвчтөнг тээвэрлэн хүргэх үйл ажиллагаа нь хоёр гуравдах шатлалын эмнэлэгт эмчлэгдэхээр заагдсан өвчний онош байдал тогтоогдсон өвчтнийг хүндрэлээс сэргийлэх, амь нас аврах үйл ажиллагаанд чиглэгдсэн байна.

### ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ :

БОЭТ-ийн эмч, эмнэлэгийн мэргэжилтэн, алсын дуудлага дуудсан ЭМБ дагаж мөрдөнө.

### ГУРАВ. ТОВЧИЛСОН ҮГ, НЭР ТОМЪЁО, ИШ ТАТСАН БАРИМТЖУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

| НЭР ТОМЪЁО | ТАЙЛБАР  |
|------------|--|
| БОЭТ       | Бүсийн оношилгоо эмчилгээний төв                       |
| ЯТТ        | Яаралтай тусламжийн тасаг                              |
| АСТ        | Амилуулах суурь тусламж                                |
| АЛТ        | Амилуулах лавшруулсан тусламж                          |
| ЭСҮ        | Эрт сэрэмжлүүлэх үнэлгээ                               |
| ААЗ        | Аюулгүй ажиллагааны зааварчилгаа                       |
| АШББ       | Анхан шатны бичиг баримт                               |
| СЭМТ       | Сумын эрүүл мэндийн төв                                |
| ХСХ        | Халдвараас сэргийлэх хяналт                            |
| ЭТҮЧАБА    | Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын алба |
| ГУДХА      | Гүйцэтгэл удирдлага дотоод хяналтын алба               |
| ЭЭДЗ       | Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал                          |

### 3.3 ИШ ТАТСАН БАРИМТ:

- ЭМС-ын 2014 оны 263 тоот тушаал
- ЭМС-ын 2019 оны А/294 тоот тушаал
- ЭМС-ын 2009 оны 388 тоот тушаал
- Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тоот тушаал
- БОЭТөв-ийн хөдөлмөрийн дотоод журам
- БОЭТ-н эмнэлгийн тусламж үйлчлгээнд мөрдөх журмууд 2012 он
- БОЭТ-өөр үйллүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, нийтлэг журам
- Америкийн зүрх судасны нийгэмлэгийн Амилуулах лавшруулсан тусламж үзүүлэх удирдамж 2016,2020 он
- Монгол улсын стандарт MNS 6717:2018 Түргэн тусламжийн бүтэц үйл ажиллагаа
- ЭМС-ын 2019 оны А/406 “Ёс зүйн хэм хэмжээ”

**ДӨРӨВ. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЭРХ МЭДЭЛ**

Хүснэгт1- Процессын үүрэг хариуцлагын матриц

| Албан тушаал<br>Процесс   | ЭЭДЗ<br>ЭТҮЧАБА | Дуудлагын<br>багийн эмч,<br>мэргэжилтэн | Алсын<br>дуудлагын<br>жолооч | Дуудлага<br>зохицуулагч<br>сувилагч | Зөвлөх<br>эмчийн<br>зөвөлгөө |
|---|-----------------|---|------------------------------|-------------------------------------|------------------------------|
| Алсын<br>дуудлагыг<br>хүлээн авч<br>бүртгэх                             | I               | I                                       | I                            | AR                                  | I                            |
| Алсын<br>дуудлагыг<br>шийдвэрлэх  | AR              | I                                       | I                            | C                                   | C                            |
| Багийг<br>идэвхижүүлэх  | C               | I                                       | I                            | AR                                  | I                            |
| Зөвөлгөө өгөх   | AR              | I                                       | I                            | C                                   | AR                           |
| Алсын дуудлага<br>гүйцэтгэх   |                 | AR                                      | AR                           |                                     |                              |
| Алсын<br>дуудлагыг<br>тайлагнах   |                 | AR                                      |                              |                                     |                              |
| Үйлчлүүлэгчийг<br>эмнэлэг хооронд<br>тээвэрлэх, эргэх<br>холбоо тогтоох | IC              | AR                                      | R                            | IAC                                 | IAC                          |

(R- гүйцэтгэх, A- хариуцах, C- хамтран ажиллах, I- мэдээлэлтэй байх)

**ТАВ. АЛСЫН ДУУДЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЗАРЧИМ :**

5.1 Үйлчлүүлэгчийн эрх, аюулгүй байдлыг дээдлэнэ.

5.2 Нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг шуурхай аюулгүй газар дээр нь үзүүлэх зарчимыг баримтална.

5.3 Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллана.

**Алсын түргэн тусламжийн дуудлага хүлээн авах**

- Харъяаллын аймгийн нэгдсэн эмнэлэг, СЭМТөвийн алсын дуудлагыг БОЭТөвийн "uvurkhangai.alsiinduudlaga@boet.ov.gov.mn" цахим хаягаар 24 цагийн турш тасралтгүй хүлээн авна.
- Зам тээврийн осол болон иргэний ирүүлсэн алсын дуудлагыг хүлээн авахад цахим шуудангаар батлагаажуулах үйлдэл хамаарахгүй бөгөөд дуудлагыг 7032103 утсаар бүртгэж хүлээн авна.
- Алсын дуудлага ирсэн даруйд дуудлага зохицуулагч ажилтан 10 минутын дотор ЭЭДЗахиралд/ захирлын эзгүйд ЭТҮЧАБА-д танилцуулж мэдээллийг хүргэн шийдвэрлүүлнэ.
- Алсын дуудлага дуудах цахим хүсэлтийг хүлээн авсан дуудлага зохицуулагч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа маягтад бүртгэн, дуудлага хүлээн авсан, дуудлагыг шийдвэрлэсэн талаар эмчлэгч эмч, эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн дарга, эмчлэгч эмч, иргэнд холбогдох утсаар мэдэгдэнэ.

- Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын нэгдсэн эмнэлэг, СЭМТөвүүд мэдээллийг илгээх техникийн боломжгүй тохиолдолд 7032103 суурин утсаар дуудлагыг хүлээн авч харилцах ба техникийн боломж бүрдсэн үед цахим шууданг нөхөн илгээнэ.

### **ЗУРГАА. АЛСЫН ДУУДЛАГЫГ ШИЙДВЭРЛЭХ**

- ЭЭДЗахирал/ЭЭДЗахирлыг эзгүйд ЭТҮЧАБА-ны дарга /алсын дуудлагатай танилцан шаардлагатай нэмэлт мэдээллийг авч дүгнэн эмч, алсын дуудлагын багийг томилох, эсвэл төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн зөвөлгөө өгүүлэх асуудлыг шийдэж, шийдвэрийг дуудлага зохицуулагчид мэдэгдэнэ.
- Зөвлөгөө өгөх тохиолдолд төрөлжсөн мэргэжлийн зөвлөх эмч, мэргэжлийн зэрэгтэй эмч нар интернет технологи, утас ашиглан зөвөлгөө өгч эмнэлзүйн зөвлөгөөний шийдвэрийг дуудлага зохицуулагч болон дуудлага шийдвэрлэсэн албан тушаалтанд мэдэгдэнэ.
- Дуудлага зохицуулагч алсын дуудлагын томилогдсон багийг идэвхижүүлж дуудлагын хуудсыг дугаарлан олгож дуудлагын багт аюулгүй байдлын зааварчилгаа өгч, жолоочид эрүүл мэндийн үзлэг хийж баталгаажуулна

### **ДОЛОО. АЛСЫН ДУУДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- ЭЭДЗахирал сар бүр мэргэжлийн чиглэлээр алсын дуудлага гүйцэтгэх эмч сувилагч, жолоочийн хуваарийг батлан мөрдөж ажиллана.
- Шаардлагатай тохиолдолд нөхөн томилгоо болон нэмэлтээр алсын дуудлагат явах эмч багийг томилох эм эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах үүргийг ЭЭДЗ хариуцна .
- Багийн ахлагчийг дуудлага шийдэрлэсэн албан тушаалтан ЭЭДЗахирал, ЭТҮЧАБА-ны дарга томилно.
- Алсын дуудлагын цүнхний бэлэн байдалд ЯТТ ахлах сувилагч тогтмол хяналт тавиж, бэлэн байдлыг бүрдүүлнэ.
- Автомашиныг тенхикийн үзлэгт жил бүр оруулан аюулгүй бэлэн байдлыг хангасан байна.
- Алсын дуудлагын эмч мэргэжилтэнг гэнэтийн ослын даатгал, хариуцлагын даатгалд жил бүр хамруулна.
- Алсын дуудлагат томилогдсон баг БОЭТөвийн Захирлын 2014 оны А/57 тоот тушаалын дагуу Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа авах ба багийн гишүүдийг гарын үсэг зуруулж баталгаажуулна
- ЭТҮЧАБА нь алсын дуудлагын үйл ажиллагааг зохицуулах журмын хэрэгжилт, бэлэн байдалд жил бүр хяналт үнэлгээ хийнэ.
- Багийн гишүүд байгаль цаг уурын нөхцөл байдалд тохируулан хувийн бэлтгэлийг хангасан байна .
- Алсын дуудлаганд томилогдсон баг нэг цагийн дотор бэлэн байдлыг хангаж дуудлаганд гарна.
- Баг газар дээр эмнэлзүйн тусламж үйлчилгээг багаар үзүүлэх бөгөөд ХСХ, эмнэлзүйн стандарт удардамж, эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд баримтлан ажиллана.
- Эмч мэргэжилтнүүд ажил үүргээ гүйцэтгэх үедээ ажлын хувцасаа бүрэн өмсөж нэр албан тушаал бүхий энгэрийн тэмдэг хэрэглэнэ.
- Эмчлүүлэгчийг эмнэлэг хооронд, лавалгаа шатлалд тээвэрлэхдээ тухайн шилжүүлж байгаа эмнэлгийн байгууллагат мэдэгдэн бэлэн байдлыг ханган эмнэлэг хүртэлх тусламжийг тасралтгүй үзүүлэн тээвэрлэнэ.
- Дуудлагын эмч, баг албан бус төлбөр /урсгуур, цус тогтоох губка, гипс, чиг, мэс заслын утас гэх мэт/ авахыг хатуу хориглоно.

- Архи согтууруулах ундаа хэрэглэсэн эмч эмнэлгийн мэргэжилтэн, жолоочийг алсын дуудлагад явуулахгүй бөгөөд дараагийн баг эмч мэргэжилтэнг томилно
- Дуудлагын эмч, баг дуудлагын хуудас томилолтыг дуудлага дуудсан эмнэлгээр баталгаажуулуулна.

## **НАЙМ. АЛСЫН ДУУДЛАГАНД АЖИЛЛАХ МЭРГЭЖЛИЙН БАГИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА**

### **8.1 Багийн ахлагчийн үүрэг:**

- Багийн ахлагч ЭЭДЗахирал болон дуудлага өгсөн СЭМТ-ийн эмчээс өвчтөний биеийн байдал, тусламж үйлчилгээ үзүүлэх бэлэн байдал нөхцөлтэй танилцаж, зайлшгүй шаардлагатай эм, цус цусан бүтээгдэхүүн, эмнэлгийн багаж хэрэгслийг нэмэлтээр авч явж болно.
- Дуудлагын ахлах эмч өвчтний эмчлэгч эмчид дуудлага очтол үргэлжүүлэн авах арга хэмжээний санал зөвлөмж өгч болно.
- Багийн ахлагч эмнэл зүйн асуудлыг багийн болон СЭМТөвийн эмч нартай хамтарсан үзлэг зөвөлгөөн хийж шийдвэр гаргана.
- Алсын дуудлагын багийн ахлагч эмч үйлчлүүлэгийн ар гэрт өвчтний биеийн байдал онош,авч хэрэгжүүлсэн эмнэл зүйн үйл ажиллгааны талаар бүрэн дүүрэн мэдээлэл өгнө.
- Алсын дуудлагын эмч, баг тусламж үзүүлсэн үйлчлүүлэгчийн биеийн байдлын талаар эмчлэгч эмчтэй холбогдож эргэх холбоотой ажиллана.
- Алсын дуудлагын гүйцэтгэлийг буцаж ирсэнээс хойш 1 хоног дотор EHEALTH программд алсын дуудлагын хуудсыг бөглөж ЭЭДЗ-д танилцуулж баталгаажуулна.
- Бусад үүрэг хариуцлага

### **8.2 Эмч нарын үүрэг хариуцлага :**

- Тухайн өдрийн алсын дуудлагын хуваарьт тавигдсан эмч өөрийн ажлаа бүрэн зохицуулсан, алсын дуудлагад явахад бэлэн байдалд байна. Зайлшгүй шаардлагаар чөлөөлөгдсөн тохиолдолд дуудлага зохицуулагч болон ЭЭДЗ-д мэдэгдэж орлон ажиллах эмчийн томилгоог хийлгэсэн байна.
- Алсын дуудлаганд томилогдсон эмч, дуудлагын мэдээлэлтэй танилцаж нэг цагийн дотор бэлэн байдлыг ханган дуудлагад гарна.
- Өвчтөнд эмнэлгийн шаардлагатай тусламжийг стандарт удирдамжийн дагуу үзүүлж өвчтөний түүхэнд тэмдэглэн баталгаажуулна.
- Өвчтөн түүний асран хамгаалагчаас шаардлагатай бүх тохиолдолд зөвшөөрөл авч баталгаажуулна.

### **8.3 Сувилагч нарын үүрэг хариуцлага :**

- Тухайн өдрийн алсын дуудлагын хуваарьт тавигдсан сувилагч өөрийн ажлаа бүрэн зохицуулсан, алсын дуудлагад явахад бэлэн байдалд байна. Зайлшгүй шаардлагаар чөлөөлөгдсөн тохиолдолд дуудлага зохицуулагч болон ЭЭДЗ-д мэдэгдэж орлон ажиллах сувилагчийн томилгоог хийлгэсэн байна.
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, нэг удаагийн хэрэгслийн нөөцийг бүрэн хангаж эмчдээ хянуулж бэлэн байдлаа хангаж явна.
- Сувилагч нь тухайн дуудлагат шаарлагатай цус цусан бүтээгдэхүүн, шинэ хөлдөөсөн сийвэнг бэлтгэх, хэрэглэсэн тохиолдолд тооцоог хариуцах, хэрэглээгүй тохиолдолд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг ханган буцааж цусны салбар төвд хүлээлгэн өгнө.
- Өвчтөнд шаардлагатай сувилахуйн тусламжийг стандарт удирдамжийн дагуу бүрэн үзүүлж, өвчтөний түүхэнд журмын дагуу тэмдэглэн баталгаажуулна.

- Бусад үүрэг хариуцлага

#### **8.4 Алсын дуудлагын жолоочийн үүрэг хариуцлага :**

- Жолооч жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байх ба дуудлагад гарахын өмнө эрүүл мэндийн үзлэгт орно.
- Алсын дуудлагын жолооч нь газарзүй, замын байрлалын талаар мэдлэгтэй, дадлага туршлагатай , амилуулах суурь тусламж үзүүлэхэд хамтран ажиллах чавдартай байна
- Алсын түргэн тусламжийн дуудлаганд гарахаас өмнө тээврийн хэрэгсэлд техникийн үзлэг хийж, аюулгүй байдлыг хангана.
- Ерөнхий санхүүчийн цохолтоор шатахуун, тослох материалыг тарифт заасны дагуу авч бэлэн байдлыг хангаж ажиллана.
- Түргэн тусламжийн үйлчилгээг MNS 6717:2018” үндэсний стандартад заасан туулах чадвартай, өвчтөн тээвэрлэхэд зориулагдсан тоноглол бүхий зориулалтын автомашинаар үйлчилнэ.
- Алсын дуудлагын багийг ажлын цагаар ажлын байран дээрээс, бусад үед байгаа байршилаас нь очиж авна.
- Жолооч нь орон нутагт очих болон буцах тухайгаа дуудлага зохицуулагч ажилтанд мэдээлнэ.
- Алсын дуудлагат явах, ирэхдээ спидометрийн заалт, шатахууны үлдэгдлийг ажлын хуудсанд бүртгэн дуудлага зохицуулагчид хүлээлгэн өгнө
- Дуудлагын машинд өвчтөн, асран хамгаалагч дуудлагын эмч багийн гишүүдээс өөр зорчигч тээвэрлэхийг хатуу хориглоно.

#### **ЕС . АЛСЫН ДУУДЛАГА ДУУДАЖ БУЙ ЭМНЭЛГИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА**

9.1 Алсын дуудлага дуудахаар шийдвэрлэж байгаа өвчтний талаарх бүрэн мэдээлэл бүхий хүсэлтийг байгууллагын тэмдэгээр баталгаажуулан БОЭТөвийн” [uvurkhangai.alsiinduudlaga@boet.ov.gov.mn](mailto:uvurkhangai.alsiinduudlaga@boet.ov.gov.mn)” цахим хаягаар ирүүлнэ. Ирүүлэх мэдээлэлд дараах агуулгыг тусгана.

Үүнд:

- Өвчтний овог, нэр, нас, регистрийн дугаар, ор хоног
- зовуурь
- Өвчний одоогийн болон амьдралын түүх
- Бодит үзлэг
- Хийгдсэн шинжилгээний өөрчлөлт/ шинжилгээг хавсрах /
- Онош
- Хийгдэж байгаа эмчилгээ дэлгэрэнгүй
- Дуудах мэргэжлийн чиглэл, тусламжийн төрлийг сонгон хүсэлтээ гаргасан байна.

9.2 Мэдээллийг илгээх техникийн боломжгүй тохиолдолд 7032103 суурин утсаар дуудлагыг өгч болох ба техникийн боломж бүрдсэн үед цахим шууданг нөхөн илгээнэ.

9.3 Дуудлага дуудсан өвчтөнд өөрийн эмнэлэгийн тусламжийн шатлалын түвшинд зайлшгүй шаардлагатай шинжилгээний урвалж, бодис, эм хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэс засал, төрөх өрөө, цахилгааны үүсгэвэр, цусны донор, нэмэлт хүний нөөцийг бэлэн байдлыг ханган ажиллах ба өвчтөнд зайлшгүй шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, цусан бүтээгдэхүүний өртөг зардлыг БОЭТөвийн нэмэмжлэхийн дагуу шилжүүлэх үүрэгтэй

9.4 Цахим зөвөлгөөн хийх боломжийг бүрдүүлсэн байна.

9.5 Дуудлагын эмч багийн аюулгүй байдал, амрах байр, хоол унд, гражаар хангана.

9.6 Өөрийн эмнэлэгт үзүүлэх боломжтой тусламж үйлчилгээнд болон ар гэрийн шахалтаар алсын дуудлага дуудахгүй бөгөөд үүнээс үүдэн гарсан зардлыг дуудлага дуудаж буй эмнэлэг хариуцан гаргана.

#### **АРАВ. АЛСЫН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГЫГ ДҮГНЭЖ ТАЙЛАГНАХ**



- Дуудлаганд явсан багийн ахлагч, мэргэжилтэн нь тусламж үйлчилгээ хэрхэн хүргэсэн талаар ажлын тайланг бичиж дуудлагын хуудсыг бөглөж 1 хоног дотор /EHealth программд шивж/ ЭЭДЗахиралд танилцуулна.
- Тусламж авсан өвчтний түүхийг шаардлагатай тохиолдолд/өвчтөн нас барсан, гэмт хэргийн шинжтэй,эхийн ноцтой хүндрэл, ховор тохиолдол/ хуулбарлан бэхжүүлж ЭТҮЧАБА, ГУДХА-д ирүүлэн чанар төлбөрийн хяналт хийлгэж үнэлүүлнэ.
- Алсын дуудлага гүйцэтгэсэн эмч, багийн ахлагч гүйцэтгэсэн ажил үүргийн талаарх мэдээллийг ЭЭДЗахиралд тайлагнан дуудлагын хуудас томилолтыг гарын үсэг зурж баталгаажуулж санхүүд хүлээлгэн өгснөөр алсын дуудлага гүйцэтгэсэн хөлс олгогдох эрх үүснэ.

#### АРВАН НЭГ. ХАРИУЦЛАГА

- Энэ журмыг зохих ёсоор биелүүлээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуваарийн дагуу ажиллаагүй цаг хугацаа оройтуулсан эмч мэргэжилтэнд байгууллагын дотоод журам, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.
- ХАБЗаавар өгч баталгаажуулаагүйгээр алсын дуудлагат гаргасан бол дуудлага зохицуулагч ажилтан хариуцлага хүлээнэ.
- Шаардаагүй дуудлага дуудсан,журмын холбогдох хэсгийг биелүүлээгүй ЭМБайгууллагын тохиолдлыг ЭМГазарт мэдэгдэн шийдвэрлүүлнэ.

#### АРВАН ХОЁР. ЭМ ЭМНЭЛЭГИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Хавсралт 1

| Доторын чиглэлийн алсын дуудлагын цүнхний эм хэрэгсэлийн жагсаалт |                        |      |             |
|---|------------------------|------|-------------|
| №   | Эм эмнэлгийн хэрэгсэл  | Нэгж | Доод хэмжээ |
| Эм тариа  |                        |      |             |
| 1   | Атропин сульфат 1мг/мл | амп  | 3           |
| 2   | Амиокардин 150мг/3.0   | амп  | 4           |
| 3   | Аминофиллин 2.4%-10    | амп  | 2           |
| 4   | Ациди-аскор 5%- 2.0    | амп  | 5           |
| 5   | Баралгин 5.0           | амп  | 3           |
| 6   | Декстроз 40%-10.0      | амп  | 6           |
| 7   | Дексаметазон 4мг-1.0   | амп  | 5           |
| 8   | Диклоденк 75мг-3.0     | амп  | 3           |
| 9   | Дицинон 2.0            | амп  | 2           |
| 10  | Дифенгидрамин 1%-1.0   | амп  | 3           |
| 11  | Допамин 20%-5.0        | амп  | 5           |
| 12  | Дротоверин 2.0         | амп  | 3           |
| 13  | Метоклопрамид 2.0      | амп  | 3           |
| 16  | Метамизол 50%-2.0      | амп  | 3           |
| 17  | Магнисульфат 25%-10.0  | амп  | 3           |
| 18  | Лидокайн2%-2.0         | амп  | 5           |
| 19  | Транлок 5.0            | амп  | 3           |
| 20  | Панангин 10.0          | амп  | 2           |
| 21  | Кальциглюконат 10%-10  | амп  | 2           |
| 23  | Фуросемид 2%-2.0       | амп  | 3           |
| 24  | Фитаминодион 1%-1.0    | амп  | 3           |
| 25  | Энап 1.25мг-1.0        | амп  | 2           |
| 26  | Эпинефрин 0.1%-1.0     | амп  | 10          |
| 27  | Натрихлорид 09%-500.0  | фл   | 2           |
| 28  | Натрихлорид 09%-250.0  | фл   | 2           |
| 29  | Натрихлорид 09%-100.0  | фл   | 2           |
| 30  | Манитол10%-250.0       | фл   | 1           |

Алсын дуудлагын үйл ажиллагааг зохицуулах журам

|                       |                              |     |    |
|-----------------------|------------------------------|-----|----|
| 31                    | Глюкоз 5%-500.0              | фл  | 1  |
| 32                    | ЕААК 5%-100.0                | фл  | 2  |
| 33                    | Рингер 250.0                 | фл  | 2  |
| 34                    | Дротоверин 10мг              | таб | 5  |
| 35                    | Валидол 0.06                 | таб | 5  |
| 36                    | Диклоденк 100 мг             | таб | 5  |
| 37                    | Метоклопрамид 10 мг          | таб | 5  |
| 38                    | Ибупрофен 400мг              | таб | 5  |
| 39                    | Нифедипин 10 мг              | таб | 5  |
| 40                    | Экватор 10/20 мг             | таб | 5  |
| 41                    | Диклоденк 100мг              | свч | 3  |
| 42                    | Кетонол 100мг                | свч | 3  |
| Нэг удаагийн хэрэгсэл |                              |     |    |
| 43                    | Ариун Бээлий                 | ш   | 5  |
| 44                    | Уян зүү 22G 20G              | ш   | 5  |
| 45                    | Хэл дарагч                   | ш   | 2  |
| 46                    | Катетрь 8,10,12,14,16.18, 20 | ш   | 2  |
| 47                    | Шээсний уут                  | ш   | 2  |
| 48                    | Дуслын систем                | ш   | 5  |
| 49                    | Шприц 20.0                   | ш   | 5  |
| 50                    | Шприц 10.0                   | ш   | 5  |
| 51                    | Шприц 5.0                    | ш   | 5  |
| 52                    | Шприц 3.0                    | ш   | 5  |
| 53                    | Шприц 1.0                    | ш   | 5  |
| 54                    | Нэг удаагийн халад           | ш   | 5  |
| 55                    | Нэг удаагийн малгай          | ш   | 10 |
| 56                    | Нэг удаагийн маск            | ш   | 10 |
| 57                    | Чангалуур                    | ш   | 1  |
| 58                    | Спирт хөвөн шарик            | ш   | 1  |

**Хавсралт -2**

| №                            | Эх барихын алсын дуудлагын цомог,<br>эм тарианы жагсаалт                    | Нэгж | Доод хэмжээ |
|------------------------------|---|------|-------------|
| <b>Нэг удаагийн хэрэгсэл</b> |   |      |             |
| 1                            | Ариун бээлий  | ш    | 8           |
| 2                            | Үзлэгийн бээлий   | Ш    | 10          |
| 3                            | Хүйн хавчаар  | ш    | 4           |
| 4                            | Хутганы ир  | ш    | 4           |
| 5                            | Тамедин 0,7   | ш    | 2           |
| 6                            | Викрил утас 0, 1,2  | ш    | 2/2/1       |
| 7                            | Шприц 3.0   | ш    | 5           |
| 8                            | Шприц 5.0   | ш    | 5           |
| 9                            | Шприц 10.0  | ш    | 5           |
| 10                           | Шприц 20.0  | ш    | 5           |
| 11                           | Шприц 60.0  | ш    | 1           |
| 12                           | Уян зүү   | ш    | 5           |
| 13                           | Систем  | ш    | 8           |
| 14                           | Шээсний уут   | ш    | 2           |
| 15                           | Катетрь   | ш    | 2           |
| 16                           | Салаалагч   | ш    | 2           |
| 17                           | Уян зүүний наалт  |      | 4           |
| 18                           | Эх барихын иж бүрдэл  | ш    | 2           |
| 19                           | Умайн хүзүүний шалгах иж бүрдэл   | ш    | 1           |
| 20                           | Нярайн даавуу   | ш    | 10          |
| 21                           | өлгий   | Ш    | 1           |
| 22                           | Дулаан тусгаарлах хөнжил  | Ш    | 1           |
| 23                           | Хярзангийн даавуу   | ш    | 10          |
| 24                           | Даралтын аппарат  | ш    | 1           |
| 25                           | Пульсоксиметр   | ш    | 1           |
| 26                           | Чагнуур   | ш    | 1           |
| 27                           | Цус тогтоох губка   | ш    | 2           |
| 28                           | Чихээс хийх ариун материал  | ш    | 4           |
| 29                           | Амбу маск, ларингоскоп , амьсгалын<br>гуурс иж бүрдэл /нярай ба том хүний / | ш    | 2           |
| 30                           | Чангалуур   | ш    | 1           |
| 31                           | Жирэмсний тест  | ш    | 5           |
| 32                           | Нэг удаагийн халад  | ш    | 5           |
| 33                           | Нэг удаагийн малгай   | ш    | 10          |
| 34                           | Нэг удаагийн маск   | ш    | 10          |
| 35                           | Нүүрний хаалт   | ш    | 3           |
| • Эм тариа                   |   |      |             |
| 36                           | Допамин 20%.5.0   | амп  | 3           |
| 37                           | Эпинефрин 0.1%-1.0  | амп  | 5           |
| 38                           | Атропин сульфат 1мг/1.0   | амп  | 2           |
| 39                           | Натрихлорид 0.9%-500.0  | фл   | 6           |
| 40                           | Рингер уусмал   | Фл   | 2           |
| 41                           | Декстран 70%  | фл   | 1           |
| 42                           | Окситоцин 5ед   | амп  | 5           |

## Алсын дуудлагын үйл ажиллагааг зохицуулах журам

|    |                       |     |   |
|----|-----------------------|-----|---|
| 43 | Мизопростол 0.2мг     | таб | 5 |
| 44 | Траниксийн хүчил 5мл  | амп | 4 |
| 45 | Магнисульфат 10%-10.0 | амп | 6 |
| 46 | Нифедипин 10мг        | таб | 6 |
| 47 | Лидокайн 2.0          | амп | 8 |
| 48 | Никардипин            | Амп | 2 |
| 49 | Диазепам 10мг -2 мл   | Амп | 2 |
| 50 | Цефазолин 1сая        | Фл  | 2 |
| 51 | Дексаметазон 4мг      | амп | 5 |
| 52 | Дифенгидрамин 1%-1.0  | амп | 3 |

**Хавсралт 3**

| №                     | Гэмтэл, мэс заслын биксний эм тарианы жагсаалт | Нэгж |  | Байх ёстой тоо |
|-----------------------|--|------|--|----------------|
| Эм тариа              |  |      |  |                |
| 1                     | Атропин сульфат 1мг/1.0                        | амп  |  | 5              |
| 2                     | Дексаметазон 4мг                               | амп  |  | 5              |
| 3                     | Диклоденк 7.5%-3.0                             | амп  |  | 3              |
| 4                     | Дифенгидрамин 1%-1.0                           | амп  |  | 3              |
| 5                     | Дицинон 2.0                                    | амп  |  | 5              |
| 6                     | Допамин 20%.5.0                                | амп  |  | 3              |
| 7                     | Дектроз 40%-10мг                               | амп  |  | 5              |
| 8                     | Новокайн 0.5%-100мл                            | фл   |  | 1              |
| 9                     | Лидокайн 2.0                                   | амп  |  | 5              |
| 10                    | Метоклопрамид 2мл                              | амп  |  | 3              |
| 11                    | Метамизол 50%-2.0                              | амп  |  | 3              |
| 12                    | Магнисульфат 25%-10мл                          | амп  |  | 2              |
| 13                    | Фуросемид 2%-2.0                               | амп  |  | 3              |
| 14                    | Фитамининодион 1%-1.0                          | амп  |  | 3              |
| 15                    | Транлок 5мл                                    | амп  |  | 5              |
| 16                    | Кетонол 2.0мг                                  | амп  |  | 3              |
| 17                    | Эпинефрин 0.1%-1.0                             | амп  |  | 5              |
| 18                    | Натрихлорид 0.9%-500.0                         | фл   |  | 2              |
| 19                    | Натрихлорид 0.9%-250.0                         | фл   |  | 2              |
| 20                    | Натрихлорид 0.9%-100.0                         | фл   |  | 2              |
| 21                    | Рингер 500.0                                   | фл   |  | 2              |
| 22                    | Манитол 10%-250.0                              | фл   |  | 2              |
| 23                    | Манитол 10%-100.0                              | фл   |  | 2              |
| 24                    | ЕААК 5%-100.0                                  | фл   |  | 3              |
| 25                    | Диклоденк 100мг                                | таб  |  | 3              |
| 26                    | Кетонол 100мг                                  | свч  |  | 3              |
| Нэг удаагийн хэрэгсэл |  |      |  |                |
| 27                    | Уян зүү  | ш    |  | 8              |
| 28                    | Уян зүүний салаалагч                           | ш    |  | 4              |
| 29                    | Ариун бээлий                                   | ш    |  | 10             |
| 30                    | Шээсний уут                                    | ш    |  | 2              |
| 31                    | Шээсний катетр 8-18                            | ш    |  | 2              |
| 32                    | Хамрын гуурс                                   | ш    |  | 2              |
| 33                    | Ходоодны зонд                                  | ш    |  | 2              |
| 34                    | Дуслын систем                                  | ш    |  | 8              |
| 35                    | Шприц 20.0                                     | ш    |  | 5              |
| 36                    | Шприц 10.0                                     | ш    |  | 5              |
| 37                    | Шприц 5.0                                      | ш    |  | 5              |
| 38                    | Шприц 3.0                                      | ш    |  | 5              |
| 39                    | Силк   | ш    |  | 4              |
| 40                    | Викрил   | ш    |  | 4              |
| 41                    | Тамедин 7.5 %                                  | ш    |  | 2              |
| 42                    | Хүчилтөрөгчийн маск /том хүн, хүүхэд/          | ш    |  | 2/2            |
| 43                    | Нэг удаагийн халад                             | ш    |  | 5              |
| 44                    | Нэг удаагийн малгай                            | ш    |  | 10             |

|                           |  |   |  |     |
|---------------------------|--|---|--|-----|
| 45                        | Нэг удаагийн маск  | ш |  | 10  |
| 46                        | Амбу маск ларингоскот<br>амьсгалын гуурс иж<br>бүрдэл/хүүхэд том хүн | ш |  | 1   |
| Боолтны материал          |  |   |  |     |
| 47                        | Уян бинт/том жижиг /   | ш |  | 5/5 |
| 48                        | Ариун бинт   | ш |  | 5   |
| 49                        | Наалт  | ш |  | 1   |
| 50                        | Хөвөн  | ш |  | 5   |
| 51                        | Сальфетка  | ш |  | 2   |
| 52                        | Гипс   | ш |  | 5   |
| Багаж хэрэгсэл            |  |   |  |     |
| 53                        | Мэс заслын хайч  | ш |  | 1   |
| 54                        | Пинцет   | ш |  | 1   |
| 55                        | Мэс заслын хутга /нэг удаагийн/                                      | ш |  | 5   |
| 56                        | Хэл дарагч /хүүхэд том хүн/  | ш |  | 2   |
| 57                        | Зүү баригч   | ш |  | 1   |
| 58                        | Чангалуур  | ш |  | 4   |
| 59                        | Зажем  | ш |  | 1   |
| 60                        | Даралтны аппарат   | ш |  | 1   |
| 61                        | Чагнуур  | ш |  | 1   |
| 62                        | Халууны шил  | ш |  | 1   |
| Эмнэлгийн тоног төхөөрөмж |  |   |  |     |
| 63                        | Хүзүүний чиг /хүүхэд том хүн /                                       | ш |  | 2   |
| 64                        | Толгойн чиг  | ш |  | 1   |
| 65                        | Мөчдийн чиг  | ш |  | 1   |
| 66                        | Нурууны чиг  | ш |  | 1   |
| 67                        | Дамнуурга  | ш |  | 1   |
| 68                        | Пульсохиметр   | ш |  | 1   |
| 69                        | Амбу маск /хүүхэд том хүн /  | ш |  | 2   |
| 70                        | Дулаан хөнжил  | ш |  | 1   |

**Жолоочийн эрүүл мэндийн үзлэгийн хуудас**

**Хавсралт 4**

|   |                                    |          |
|---|------------------------------------|----------|
|   | Жолоочийн овог нэр<br>Огноо        | Үзүүлэлт |
| 1 | Зовуурь                            |          |
| 2 | Пульс                              |          |
| 3 | Артерийн даралт                    |          |
| 4 | Алкотестерийн заалт /Drager /      |          |
| 5 | Дүгнэлт                            |          |
| 6 | Жолоочийн гарын үсэг               |          |
| 7 | Дуудлага зохицуулагчийн гарын үсэг |          |

**Журмын шалгуур үзүүлэлт**

| дд | Шалгуур   | Босго | 2023 оны зорилт |
|----|---|-------|-----------------|
| 1  | Нотлогдсон гомдол                                     | 0     | 0               |
| 2  | Нэхэмжлэхийн шаардлага хангаагүй дуудлагын хувь-өртөг | 0     | 0               |
| 3  | Эм эмнэлгийн хэрэгсэлийн бэлэн байдлын хангалт        | 95%   | 95%             |
| 4  | 1 цагийн дотор гарсан дуудлагын хувь                  | 50%   | 70%             |
| 5  | Анхан шатны бичиг баримтын бүртгэл баталгаажуулалт    | 50%   | 80%             |